



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.m0n](https://facebook.com/Rtcc.m0n)
- [g http://rtcc.mrtd.gov.mn](http://rtcc.mrtd.gov.mn)
- [✉ info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)
- [☎ +976 77244409](tel:+97677244409)

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

2018 оны 7-р сарын дугаар



Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагуудын хоногийн болон сарын статистик мэдээг салбарын мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байна. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлтийн мэдээ
- Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ /өссөн дүнгээр/
- Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/
- Дамжин өнгөрөх ачааны мэдээ /чиглэл, зуучлагч, төрлөөр, өссөн дүнгээр/
- Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ /чиглэл, зуучлагчаар, өссөн дүнгээр/
- Зорчигч тээвэрлэлтийн мэдээ
- Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын мэдээнүүд багтаж байна.



“British Railway Modelling”, “Railway Magazine”, “Railway Digest” сэтгүүлүүдийн дугаарыг төвийн сайтад байршууллаа

2018 оны долоодугаар сард British Railway Modelling, Railway Magazine, Railway Digest сэтгүүлийн дугааруудыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэлээ. RailwayDigest сэтгүүлийн 29-р хуудаснаас Олон улсын өндөр хурдны төмөр зам, Railway Magazine 80-р хуудаснаас төмөр замын цэцэрлэгт хүрээлэнгийн тухай мөн “Симс” компанийн сүүлд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр зэрэг сонирхолтой мэдээ мэдээллийг харах боломжтой.

SIEMENS WINS £1.5BILLION PICCADILLY LINE ORDER

The RAILWAY Magazine

BRITAIN'S BEST-SELLING RAIL TITLE July 2018

West Coast Railways' Lake District lifeline

■ £5bn rail investment for Wales
New trains, new Identity, electrification and more

■ GBRf buys 16 Class 56s

CLASS 66 - FREIGHT WITHOUT FRONTIERS FRANCO-CROSTI LOCOMOTIVES ALTERNATIVE FUELS FOR TRAINS

WORLD'S THIRD OLDEST LOCOMOTIVE DISCOVERED ON TYNESIDE

ON YOUR FREE DVD
PENDON Pt. 2, A TRIP TO TMC, INSIDE HATTONS

BRITISH RAILWAY MODELLING

BRM VINTAGE

STOP PRESS! STOP PRESS! STOP PRESS!
MAJOR NEWS FROM HORNEY AND BACHMANN

CLASSIC LAYOUTS & TRUSTED TECHNIQUES IN OO, 0, EM AND 2FS

ALSO THIS ISSUE

- GRASS, BEFORE IT WAS STATIC
- TRI-ANG RETROSPECTIVE
- BORCHESTER TRACKPLAN SPECIAL and more...

EXCLUSIVE

BRM MEETS DAVE ROWE

REVIEWED: MINERYA, IRON MINK, DIGITAL SOUND CONTROLLER, 500 SIGNALS, TMC BOLSTER WAGONS





Төмөр замын тээврийн 2018 оны 6-р сарын статистик мэдээ

2018 оны 2-р улирал: Зорчигч тээвэрлэлт 2018 оны хоёрдугаар улиралд 235.9 мян.зор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.19%-аар буурсан, ачаа тээвэрлэлт нь 2018 оны хоёрдугаар улиралд 9093.2 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 17.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ




Суурь бүтцийн 2018 оны 7-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын тайлан


2018 оны 7-р сард нийт 226 тасалдал, 278,4 галт тэрэг цагийн барилт үүсэж, 47,42 сая төгрөгийн хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:

Тасалдлын хэмжээ, тоо



Тасалдлын хэмжээ, г/т цаг




Тасалдлаас үүссэн хохирол, сая төг



Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 39-н нэгж буюу 20,85%, 29,6-н цаг буюу 11,9%-иар, хохирлын хэмжээ 0,76 сая төгрөг буюу 1,63%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд:

Тасалдлын тоо



■ техникийн saatал ■ технологийн зөрчил ■ бусад

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих тухай” 23 дугаар тушаалын дагуу 2018 оны II дугаар улирлын байдлаар дотоодын үйлдвэрлэлээс хийсэн худалдан авалтын тайланг албан бичгээр ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад хүргэж танилцууллаа.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.07.06-ны 01/3293 дугаартай албан бичгийн хүрээнд Монгол Улсын 2019 оны төсвийн төслийн ЗТХ-ийн сайд, төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусгах саналыг Засгийн газрын 2018 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу боловсруулж ЗТХ-ийн сайдад танилцууллаа.



Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага /ОСЖД/-ын мэдээлэл ба кодчиллын “Мэдээллийн сан болон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал” санамж бичгийн орчуулгын төсөлд санал авахаар салбарын ТББ-уудад албан бичиг хүргүүллээ.



Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9-д заасан “Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлал”-ын төсөлд тусгах саналыг албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргэж танилцууллаа.





Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д заасан төвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой “Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам”-ын 6.1, 6.5 дахь заалтыг хэрэгжүүлж галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, суурь бүтэц эзэмшигчийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх 2017-2018 оны өвлийн цагийн хуваарийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийлээ.



“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын захирлын 2016 оны А/14 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар дугаар олгох журам”, Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага MNS 6630-2:2016” стандартыг үндэслэн 11 ачааны хагас вагонд шинэ дугаар олгогдлоо.



Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага MNS 6630-2:2016” стандартыг үндэслэн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлж “УБТЗ” ХНН-ийн 76 хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олголоо.




Мэдээ, мэдээлэл




Төвийн албан хаагчид сургалт, мэдээллийн арга хэмжээнд тогтмол хамрагдаж байна

“Хэрхэн амжилттай амьдрах ба хувь хүний хөгжлийн асуудлууд”, “Хүнийг болон өөрийгөө таних нь” болон “Компьютер, интернет орчин, албан бичгийн хэрэгт баримтлах дүрэм” сэдвээр төвийн ажилчдын дунд сургалт зохион байгуулагдлаа. Мөн ЗТХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий ОТБЗ-ийн болон Монгол Улсад төмөр замын тээврийн салбар үүсэн байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийн хурлуудад төвийн удирдлагууд болон албан хаагчид оролцлоо.



- Хэрхэн амжилттай амьдрах ба хувь хүний хөгжлийн асуудалд
- Хүнийг болон өөрийгөө таних нь



Өнөөдөр миний амжилтын өдөр

• Өөртөө “за” гэж хэлэхээс илүү бусад “за” гэж хэлэх нь өөрийн үнэлгээж муу байгаагийн шинж

• Хэдий “үгүй” гэж хэлмээр санагдсан ч, та хэр олон удаа бусад “за” гэж хариулж байсан бэ?

Дургуй мөртлөө “за” гэж хэлдэг зуршил танд байна уу? Энэхүү жижиг шалгуураар өөрийгөө шалгаад үзүү.

Компьютерийн хэрэглээ

> Secure connection

🔒 https:// www.securesites.com



> Unsecured connection

HTTP:// www.unsecuredsite.com





 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
З-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

